



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 1/158

Номгон

“Соёлтой-Баянхонгорчууд” арга хэмжээг
хэрэгжүүлэхэд зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Соёлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, 24 дүгээр зүйлийн 1.1, 30 дугаар зүйлийн 1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 7.1.6, 7.1.9, 7.1.11, 16 дугаар зүйлийн 1.1, 1.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөг батлах тухай” 4/27 дугаар тогтоолын 62-р заалт, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1, 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Соёлтой-Баянхонгорчууд” арга хэмжээг бүх нийтийг соён гэгээрүүлэх, соёлын боловсролыг дээшлүүлэх, соёлын биет бус өвийг хамгаалах, олон нийтэд сурталчлан таниулах агуулгаар 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл зохион байгуулсугай.


2.Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3.Арга хэмжээнд шаардагдах 10,000,000 (Арван сая) төгрөгийг Аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

4.“Соёлтой Баянхонгорчууд” арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, холбогдох тайлан мэдээллийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор тайлагнаж ажиллахыг Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар (Б.Пүрэвдагва)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН



Аймгийн Засаг даргын ... 2025 оны 03 дугаар
сарын 24-ний ... өдрийн 17 дугаар
захирамжийн захиралт



“СОЁЛТОЙ-БАЯНХОНГОРЧУУД” АРГА ХЭМЖЭЭГ
ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

2025 оны 03 дугаар сарын 20

Номгон

№	Материалын зардал	Хугацаа	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6	7
1	Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр “Соёл түгээгч” цуврал контент, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	2025.04.15	Тоо	1	3000	2,500,000
2	Соёлын боловсролын “Цүнхтэй хөтөлбөр” сургалтын багц бэлтгэх	2025.05.15	Багц	180	15000	2,700,000
3	Соёлын биет бус өв өвлөн уламжлагчдын анхдугаар чуулган зохион байгуулах	2025.06.15	тоо	1	2800000	2,800,000
4	Монгол улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 17 дугаар зарлиг, мөн 2024 оны 02 сарын 01 өдрийн 09 дүгээр “Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх тухай” зарлигийн хүрээнд зохион байгуулагдах “Их шавийн эгшиглэн” морин хуурын тоглолт зохион байгуулах	2025.03.15	тоо	1	2000000	2,000,000

Нийт зардал

10,000,000

оОо